

09-р сарын 24-ний өдөр
Тогтоолын Хавсралт



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

ДУГААР

--

НУУЦЫН ЗЭРЭГ

C1

ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

ТУЗ, эрх бүхий албан тушаалтан, хувьцаа эзэмшигч, бусад оролцогч талууд

ТАНИЛЦАХ

Нийт ажиллагсад, хувьцаа эзэмшигч,
бусад оролцогч талууд


ХАРИУЦАХ НЭГЖ

Санхүүгийн алба

БОЛОВСРУУЛСАН

Гарын үсэг	
Нэр, албан тушаал	А.Жавхлан, Санхүүгийн менежер

ХЯНАСАН

Гарын үсэг	
Нэр, албан тушаал	Л.Цолмон, Гүйцэтгэх захирал

ӨӨРЧЛӨЛТ

Хувилбар	Тэмдэглэл
1.0	2025 оны 09-р сарын 24-ны өдөр шинээр боловсруулсан.

	ГАРЧИГ	Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр						
	ДУГААР		ХУВИЛБАР	1.0	НУУЦЫН ЗЭРЭГЛЭЛ	C1	ХУУДАСНЫ ДУГААР	2

1. Нийтлэг үндэслэл

1.1. Зорилго

Энэхүү Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр ("**Хөтөлбөр**")-ийн зорилго нь Финко Капитал ББСБ ХХК ("**Компани**")-ийн хувьцаа эзэмшигч, ирээдүйн хөрөнгө оруулагч, санхүүгийн зах зээлд оролцогчдод Компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдал, засаглал, стратегийн зорилтын хэрэгжилт, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэлийн талаар мэдээлэл хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хамрах хүрээ

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("**ТУЗ**")-ийн гишүүд, түүний нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан болон Компанийн хувьцаа эзэмшигчид энэхүү Хөтөлбөрийг дагаж мөрдөнө. Энэхүү Хөтөлбөрийг аливаа сонирхогч этгээдийн хүсэлтээр танилцуулж болох ба Компанийн цахим хуудаст байршуулж болно.

1.3. Хяналт, нэмэлт өөрчлөлт

Энэхүү Хөтөлбөрийг Санхүүгийн алба 3 жил тутамд хянаж шаардлагатай бол түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар ТУЗ-д танилцуулах ба аливаа өөрчлөлтийг ТУЗ баталснаар хүчин төгөлдөр мөрдөнө.

1.4. Хөтөлбөрийн нөхцөл

Энэхүү Хөтөлбөр нь Монгол Улсын хууль тогтоомж, компанийн бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журам, зааварт нийцсэн байна. Энэхүү Хөтөлбөрийн заалтууд хэрхэн тайлбарлах талаар тодорхойгүй байдал, санал зөрөлдөөн үүссэн, Хөтөлбөрт тусгагдаагүй аливаа асуудал гарсан тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын журам, зааврыг дагаж мөрдөнө.

2. Хөрөнгө оруулагчидтай харилцах

2.1. Компани нь шаардлагатай тохиолдолд дор дурдсан мэдээллийг Компанийн цахим хуудсаар дамжуулан эсвэл тухайн хөрөнгө оруулагчтай харилцан тохирсон аливаа бусад хэлбэрээр хүргэх боломжийг хангасан байна.

- 2.1.1. Компанийн товч танилцуулга,
- 2.1.2. Компанийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан,
- 2.1.3. ТУЗ-ийн бүрэлдэхүүн ба ТУЗ-ийн гишүүдийн товч танилцуулга,
- 2.1.4. Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл,
- 2.1.5. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлын тайлан,
- 2.1.6. Компанийн засаглалтай холбоотой мэдээллүүд, болон
- 2.1.7. Бусад шаардлагатай мэдээлэл.

3. Бусад

3.1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулна.

3.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд Санхүүгийн алба хяналт тавина.